

**СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ
ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ
ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН /2024 он/**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Стандартчилал, тохирлын үнэлгээний хяналт зохицуулалтын тухай хуулийн төслийн холбогдох зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга² хэлбэрээр боловсруулагдсан байна.

Стандартчилал, тохирлын үнэлгээний хяналт зохицуулалтын тухай хуулийн төслийг /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”³-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараахь үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН
БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д⁴ заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараахь 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Харилцан уялдаа зэрэг болно.

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

- **Зорилгод хүрэх байдал:**

¹ www.legalinfo.mn. Сүүлийн нэвтрэлт 2020 оны 11 дугаар сарын 28-ны өдөр.

² 24.1.Нийгмийн харилцааны тулгамдсан асуудлыг харгалзан тухайн хуульд нэмэлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, эсхүл тодорхой зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох асуудлаар хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

³ www.legalinfo.mn. Сүүлийн нэвтрэлт 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдөр.

⁴ Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 "... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно".

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ **Ойлгомжтой байдал:**

Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд⁵ заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ **Харилцан уялдаа:**

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой, мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай. Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг⁶ хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараахь байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

		шаардлага, шалгуурыг хангасан шалгах.
--	--	---------------------------------------

1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Стандартчилал, тохирлын үнэлгээний хяналт зохицуулалтын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Энэ дагуу хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл хүчин төгөлдөр хуулийн зохицуулалтыг өргөжүүлж, дараахь зорилтуудад тулгуурлан шинэчлэхээр зорьсон байна:

- 1) стандартын талаарх тодорхойлолтод сонгон хэрэглэх баримт бичиг гэж заасан нь иргэд, аж ахуйн нэгжид төөрөгдөл, тодорхойгүй байдал үүсгэж байна. Тухайлбал, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн дагуу Засгийн газраас тохирлын үнэлгээнд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд стандартыг тодорхойлон заадаггүй нь хяналт шалгалтын нэгдмэл, ойлгомжтой байдлыг алдагдуулж байгааг өөрчлөх
- 2) Хуулийн дагуу хэрэгжилтийн хяналтын тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох боломж нээлттэй боловч хувийн хэвшлийн оролцоо, эрх хэмжээг нарийвчлан тодорхойлох
- 3) итгэмжлэлийн үйл ажиллагааны үр дүнд тохирлын үнэлгээний байгууллага ажиллагаа явуулахаар заасан боловч тухай салбарт тохирлын үнэлгээг хариуцан гүйцэтгэх итгэмжлэгдсэн, мэргэшсэн байгууллагыг Засгийн газрын гишүүн томилж байгаа нь хувийн хэвшлийн байгууллагад шат дамжлага нэмэгдүүлсэн, зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлснийг өөрчлөх
- 4) Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартын хувьд иргэд, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдлын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгох
- 5) тохирлын үнэлгээ болон тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаарх зохицуулалтыг нарийвчлан тусгаж, техникийн зохицуулалт, заавал дагаж мөрдөх стандартуудын талаарх зах зээлд нийлүүлэгдэж хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн ашиг сонирхолд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны найдвартай байдал хангах

Түүнчлэн хуулийн төсөд тусгаснаар энэ хуулийн зорилт нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ түүний итгэмжлэлийн эрх зүйн үндсийг тогтоож, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалах, хяналт тавих, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байна.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг дараах байдлаар бүлэглэн шалгаж үзвэл:

1.Хуулийн төслийн 21.2 дахь заалтад “Хууль тогтоомж, техникийн зохицуулалт, олон улсын гэрээнд эш татсан стандартчиллын баримт бичгийг заавал дагаж мөрдөнө.” гэж заасан байна. Хэдийгээр хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан стандартын талаарх тодорхойлолтод сонгон хэрэглэх баримт бичиг гэж заасан нь иргэд, аж ахуйн нэгжид төөрөгдөл, тодорхойгүй байдал үүсгэж байгааг өөрчлөх зорилгод хүрэхийн тулд энэхүү

заалтыг тусгасан боловч энэхүү зохицуулалт тусгасан тохиолдолдүүнтэй холбогдуулан дагалдан боловсруулах хуулийн төслүүдийг сайтар олж тогтоох шаардлага үүсэхийг анхаарч тооцох шаардлагатай.

2.Хуулийн дагуу хэрэгжилтийн хяналтын тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох боломж нээлттэй боловч хувийн хэвшлийн оролцоо, эрх хэмжээг нарийвчлан тодорхойлох зоригод хүрэх зохицуулалт нь хуулийн төслийн 7.1.6 дахь заалтад хариуцсан асуудлаар төлбөртэй ажил, үйлчилгээ эрхлэх, сургалт явуулах”;, мөн төслийн 7.1.7 дэх заалтад “стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр шинжлэх ухаан, технологийн судалгаа, шинжилгээ хийх, энэ хуулийн 7.1.6-д заасан ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;” гэсэн заалтаар дамжих хэрэгжих боломжтой байна. Хувийг хэвшил рүү хандсан тэдний ороцоог хангасан зохицуулалт үүнээс өөр дэвшилтэтд зохицуулалт байхгүй байгаад анхаарч, дээрх зохицуулалтаас гадна хуулийн төсөлд заасны дагуу байгуулах Зөвлөл, хорооны бүрэлдэхүүнд хувийн хэвшлийн ороцоог хангах, шардлагатай бол Худалдаа аж, үйлдвэрийн танхимын төлөөллийг оролцуулах замаар шийдвэрлэх боломжтойг анхаарах

3.Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартын хувьд иргэд, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдлын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгоход зорилгол чиглэсэн зохицуулалт хангалтгүй байна. Иймд үзэл баримтлалд тусгагдсан тус зорилгыг хангахад чиглэсэн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

4.Хуулийн төслийн зохицуулалтууд нь бүхэлдээ тохирлын үнэлгээ болон тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаарх зохицуулалтыг нарийвчлан тусгаж, техникийн зохицуулалт, заавал дагаж мөрдөх стандартуудын талаарх зах зээлд нийлүүлэгдэж хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн ашиг сонирхолд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны найдвартай байдал хангах зорилгод чиглэгдсэн байна гэж үзэхээр байна.

Хуулийн төслийн шинэчлэн найруулга хэлбэрээр боловсруулсан байх бөгөөд дараах давхардал, хийдэл, зөрчил үүссэн байгааг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

1.Хуулийн төслийн нэрийг өөрчилсөн талаар хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхой тусгаагүй байна. Хуулийн төслийн үзэл баримтлалын нэрийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нэрээр тусгаж, харин үзэл баримтлалдаа шинээр нэрлэх хуулийн нэрийг өөрчлөн тусгах талаар тусгайлан тусгахыг анхаарах;

2.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.” гэж заасан. Хуулийн төслийн холбогдох заалтуудад стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн “төв байгууллага” гэж тусгасан нь хууль батлагдсаны дараа хууль хэрэглээнд тодорхойгүй байдал үүсдэгийг анхаарч Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн “төрийн захиргааны байгууллага” гэж хүчин төгөлдөр хуульд тусгасан агуулгыг хэвээр нь үлдээх;

3.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Агентлагийг Засгийн газрын тухай хуулийн 18³дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу томилогдсон дарга тэргүүлнэ.” гэж заасан. Иймд хуулийн төслийн 6.4 дэх хэсэгт заасан “Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төв

байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, Засгийн газар томилж, чөлөөлнө.” гэж давхардуулан тусгах шаардлагагүй юм. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7 дахь заалтад “бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх” гэж заасанд нийцэхгүй болно.

4. Хүчин төгөлдөр Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.” гэж заасан. Гэтэл хуулийн төслийн 6.5 дахь хэсэгт Аймаг, нийслэлийн стандартчилал, тохирлын үнэлгээний байгууллагын даргыг Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төв байгууллагын дарга томилж, чөлөөлөхөөр тусгажээ. Өөрөөр хэлбэл аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөхгүйгээр шууд томилох асуудлыг тусгажээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн орон нутгийн хэрэгжүүлж байгаа чиг үүрэг, түүнчлэн мөн хуульд заасны дагуу нийслэлийн чиг үүрэгт стандарт хэрэгжүүлэх асуудал мөн харьяалагдаж байгааг анхаарах, мөн энэ нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй зарчмын өөрчлөлт байгааг анхаарч, шаардлагатай бол энэхүү өөрчлөлтийн талаар хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхой тусгах ;

5. Хуулийн төслийн 7.1.1 дэх заалтад Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төв байгууллага стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний дүрэм, журам, заавар, боловсруулах, батлахаар тусгажээ. Журмаар зохицуулах харилцааг аль болох хуулийн төсөлд тусгах замаар шийдвэрлэх, зайлшгүй шаардлагатай бол Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн тусгайлан батлах журмын нэр, зохицуулах асуудлын тодорхой тусгах нь зүйтэй. Энэ нь хууль батлагдасаны дараа хуулийг хэрэгжүүлэх баталгааг нэмэгдүүлэх ач холбогдолтойг анхаарах;

6. Хуулийн төслийн 7.1.9. дэх заалтад “энэ хуулийн 22.1 дэх хэсэгт заасан бүтээгдэхүүний баталгаажуулалтыг хэрэгжүүлэх шинжээчид тавих шаардлагыг тогтоох, шинжээчийн эрх олгох, цуцлах”; мөн төслийн 7.1.10 дахь заалтад “стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулах эрх олгох, цуцлах;” асуудлыг тусгажээ. Зөвшөөрлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “зөвшөөрөл” гэж зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс хуульд заасан хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу тодорхой үйл ажиллагааг эрхлүүлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахаар олгосон эрхийг; ойлгохоор заасан.

Иймд хуулийн төсөлд тусгасан дээрх үйл ажиллагаад нь нэг төрлийн зөвшөөрөлд хамаарах үйл ажиллагаа байх тул Зөвшөөрлийн тухай хуульд “Хуульд зааснаас бусад тохиолдолд Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээд аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглоно.” гэж заасыг мөн баримтлах шаардлагатай. Төсөлд тусгасан шинжээчийн эрх олгох, цуцлах асуудал нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуульд байгаа зохицуулалт тул

Зөвшөөрлийн тухай хуульд нийцсэн зохицуулалт гэж үзэж болох юм. Харин стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулах эрх олгох, цуцлах асуудлыг “зөвшөөрөл” хэлбэрт оруулахаас зайлсхийж харин бүртгэлийн хэлбэрээр явуулж болохыг хуулиар зөвшөөрсөн тул Зөвшөөрлийн тухай хуулийн энэхүү зохицуулалтыг ашиглах;

7.Хуулийн төслийн 15.3 дах хэсэгт “Шаардлагатай тохиолдолд техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх журмыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны “шаардлагатай тохиолдолд” тодорхойгүй заасныг тодорхой болгох;

8.Хүчин төгөлдөр Сандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль болон Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд “хотын стандарт”-ын асуудлыг зохицуулсан. Тус стандарт буюу ойлгомжгүй байдлыг арилгахад чиглэсэн зохицуулалт тусгасан нь сайшаалтай. Гэвч үүнтэй холбогдуулан дагалдуулан боловсруулах хуулийн төслүүд, тухайлбал, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг анхаарах;

9.Хуулийн төслийн 30.2 дахь хэсэгт итгэмжлэлийн асуудал эрхэлсэн байгууллаг нь төрийн захиргааны байгууллага байхаар тусгажээ. Хүчин төгөлдөр хуулийн төсөлд итгэмжлэлийн байгууллага гэсэн агуулгаар заасан байдаг.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.” гэж, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн дагуу тухайн үйл ажиллагааны зохих хүрээ, Ерөнхий сайд, сайдын саналыг үндэслэн Засгийн газар байгуулна.” гэж заасан. Өөрөөр хэлбэл төрийн захиргааны байгууллага буюу агентлагийг хуулиар байгуулж болох боловч энэ нь хуульд заасан дээрх шаардлагыг хангах эсэхийг судалж хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхой тусгасаны үндсэн дээр хуулийн төсөлд тусгах ёстой. Итгэмжлэлийн байгууллага болон итгэмжлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хуулийн нэр томъёоны хувьд ялгаатай бөгөөд үүнийг хуулийн төсөлд дахин нягталж тодорхой болгох эсхүл үзэл баримтлалд тусгах;

10.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад “хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх;” мөн хуулийн 10.1.3. дах заалтын дагуу хуульд хаалттай мэдээлэл гэж зааж болох зохицуулалттай. Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Хаалттай мэдээлэлтэй хуульд заасанд үндэслэл, журмын дагуу танилцаж, ашиглаж, ил болгоно.”, мөн зүйлийн 10.3 дахь хэсэгт “Хүнд хамаарах хаалттай мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрлөөр хуульд заасан зорилго, нөхцөл, журмын дагуу ашиглана.” Гэж тус тус заасан. Иймд хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд хаалттай мэдээллийг ашиглахтай холбоотой зохицуулалтыг тодорхой тусгах;

10.Хуулийн төслийн 35.2 дахь хэсэгт “стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь Төсвийн тухай хуулийн 46.2-т заасан журмын дагуу үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос стандартчилал, техникийн зохицуулалтын техникийн шинэчлэл, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зардлыг санхүүжүүлнэ.” гэж тусгасан байна. Энэ нь хүчин төгөлдөр хуульд байгаа зохицуулалт боловч Төсвийн тухай хуулийн 3

дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт “Төсвийн харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулах бөгөөд орон нутаг, салбарын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрийн хэмжээг хуульчлан тогтоох, түүнийг хуваарилах аливаа харилцаа үүнд нэгэн адил хамаарна.” гэж заасантай зөрчилдөхийг анхаарах.

2. Ойлгомжтой эсэх:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Мөн хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан үнэлсэн хийсэн болно.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7-д заасан хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Мөн тус хуулийн төслийг дагалдан боловсруулагдсан хуулийн төслүүд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсэгт заасан дугаарлалт болон хуулийн төслийн заалтын байршилд тавигдах шаардлагыг хангасан байна.

Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3-т заасанд нийцсэн байна.

4.Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 –т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зарчмын томоохон зөрчил байхгүй байна. Харин зарим нэг тодруулах, уялдааг хангах, сайжруулах шаардлагатай асуудлыг үнэлгээний Зөвлөмж хэсэгт тусгасан болно.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах,	Энэхүү хуулийн төсөлд зүйл, заалт хооронд эшлэл хэрэглэсэн байна. Иймд хуулийн төслийн зохицуулалтын өөрчлөлт, засварыг

	энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	харгалзан, эшлэлийг нягтлах нь зүйтэй байна.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх	Тус хуулийн төслийг дагалдаж нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан тус тус боловсруулсан байна.

- Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хангаж байна.
2	Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Үгүй	Энэхүү шаардлагыг хангасан байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Дүн шинжилгээний хүрээнд хуулийн төслийн зарим заалт өөр хоорондоо зөрчилдсн байх тул залруулах шаардлагатай бөгөөд үнэлгээний Зөвлөмж хэсэгт тусгасан болно.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Тийм	Давхардсан агуулга бүхий зохицуулалт байхгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна. <i>Жич: Нэмэлт оруулах зохицуулалтын талаар Зөвлөмж хэсэгт тусгасан.</i>
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага,	Тийм	Энэхүү зохицуулалтыг нарийвчлан тодорхой зарчмыг тогтоосон байна.

	мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх		
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Тийм	Хязгаарлалт нь Үндсэн хуульд заасан зарчимд нийсэн хэмээн дүгнэсэн.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	-	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрх хэмжээг хэрэгжүүлэх явцад хүнд суртал, авлигаас сэргийлэхэд чиглэсэн тодорхой зохицуулалт нэмэлтээр тусгах шаардлагатай гэж дүгнэж байна.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	-	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт нь Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдсөн зохицуулалт байхгүй, харин хууль зүйн техникийн хувьд хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах шаардлагатай зарим асуудал байна. Тухайлбал,

1.Хуулийн төслийн нэрийг өөрчилсөн талаар хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхой тусгаагүй байгаад анхаарч Хууль тогтоомжийн тухай хуулийн аргачлалд заасны дагуу Түүнчлэн хуулийн өслийн үзэл баримтлалын нэрийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нэрээр тусгаж, харин үзэл баримтлалдаа шинээр нэрлэх хуулийн нэрийг тусгайлан өөрчлөн тусгах талаар тусгахыг анхаарах;

2.Хуулийн төслийн бүтцийн хувьд талаас илүү хувь буюу ихэнх зохицуулалт нь байгууллагын тогтолцоо, эрх бүхий этгээдийн бүрэн эрхийн талаарх зохицуулалт байгааг анхаарч хуулийн төслийн зорилгод нийцүүлэн стандартчлал тохирол, техникийн зохицуулалтын үйл ажиллагааг одоо байгаагаас илүү процесжуулах, зохицуулалтын шинжтэй заалтуудыг нэмэгдүүлж, иргэн хуулийн этгээдэд болон хэрэгжүүлэх этгээдэд тодорхой болгоход анхаарах;

3.Хуулийн төслийн бүлгийн дарааллын дахин нягталж, стандартчлал тохирол техникийн зохицуулалтын үйл ажиллагаатай холбоотой бүлгүүдийг эхэлж тусгах, дараа нь

түүнийг хэрэгжүүлэх этгээдийн эрх үүрэг байгууллагын тогтолцоо, санхүүжилт, хариуцлага бусад зүйл гэсэн дарааллаар шинэчлэн тогтоох;

4. Шилжилтийн үеийн зохицуулалт шаардлагатай эсэхийг тухайлан анхаарах шаардлагатай. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл боловсруулах замаар зохицуулах боломжтойг анхаарах.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нөлөө тооцох үнэлгээг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ. Үнэлгээнд хуулийн төсөл, үзэл баримтлалаас гадна статистик тоон үзүүлэлтүүд, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд, хуулийн төсөлд ирүүлсэн санал зэрэг нэмэлт материалыг ашигласан болно.

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараахь **Дүгнэлтийг** хийж, **Зөвлөмж** боловсрууллаа:

Дүгнэлт:

Зорилгод хүрэх байдал: Хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг тусгасан байна. Гэвч зохицуулалтыг илүү нарийвчлах, хэрэгжих боломжийг нь нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна. Тухайлбал,

1. Хуулийн төслийн 21.2 дахь заалтад “Хууль тогтоомж, техникийн зохицуулалт, олон улсын гэрээнд эш татсан стандартчиллын баримт бичгийг заавал дагаж мөрдөнө.” гэж заасан байна. Хэдийгээр хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан стандартын талаарх тодорхойлолтод сонгон хэрэглэх баримт бичиг гэж заасан нь иргэд, аж ахуйн нэгжид төөрөгдөл, тодорхойгүй байдал үүсгэж байгааг өөрчлөх зорилгод хүрэхийн тулд энэхүү заалтыг тусгасан боловч энэхүү зохицуулалт тусгасан тохиолдолдүүнтэй холбогдуулан дагалдан боловсруулах хуулийн төслүүдийг сайтар олж тогтоох шаардлага үүсэхийг анхаарч тооцох шаардлагатай.

2. Хуулийн дагуу хэрэгжилтийн хяналтын тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох боломж нээлттэй боловч хувийн хэвшлийн оролцоо, эрх хэмжээг нарийвчлан тодорхойлох зоригод хүрэх зохицуулалт нь хуулийн төслийн 7.1.6 дахь заалтад хариуцсан асуудлаар төлбөртэй ажил, үйлчилгээ эрхлэх, сургалт явуулах”; мөн төслийн 7.1.7 дэх заалтад “стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр шинжлэх ухаан, технологийн судалгаа, шинжилгээ хийх, энэ хуулийн 7.1.6-д заасан ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;” гэсэн заалтаар дамжих хэрэгжих боломжтой байна. Хувийг хэвшил рүү хандсан тэдний ороцоог хангасан зохицуулалт үүнээс өөр дэвшилтэтд зохицуулалт байхгүй байгаад анхаарч, дээрх зохицуулалтаас гадна хуулийн төсөлд заасны

дагуу байгуулах Зөвлөл, хорооны бүрэлдэхүүнд хувийн хэвшлийн ороцоог хангах, шардлагатай бол Худалдаа аж, үйлдвэрийн танхимын төлөөллийг оролцуулах замаар шийдвэрлэх боломжтойг анхаарах

3.Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартын хувьд иргэд, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдлын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгоход зорилгол чиглэсэн зохицуулалт хангалтгүй байна. Иймд үзэл баримтлалд тусгагдсан тус зорилгыг хангахад чиглэсэн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

4.Хуулийн төслийн зохицуулалтууд нь бүхэлдээ тохирлын үнэлгээ болон тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаарх зохицуулалтыг нарийчлан тусгаж, техникийн зохицуулалт, заавал дагаж мөрдөх стандартуудын талаарх зах зээлд нийлүүлэгдэж хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн ашиг сонирхолд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны найдвартай байдал хангах зорилгод чиглэгдсэн байна гэж үзэхээр байна.

Ойлгомжтой байдал: Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээ боловсруулагдсан ойлгомжтой байна. Гэвч хуулийн төслийн зарим нэр томъёог жигдлэх, ойлгомжтой томъёолох шаардлагатай байна.

Харилцан уялдааг хангасан байдал: Хуулийн төслийн зохицуулалт өөр Үндсэн хуультай зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна. Харин тус хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Зөвлөмж

Хуулийн төсөлд дараахь агуулгын чанартай зохицуулалт нэмэх, тодруулах шаардлагатай байна. Үүнд:

1.Хуулийн төсөлд “Хууль тогтоомж, техникийн зохицуулалт, олон улсын гэрээнд эш татсан стандартчиллын баримт бичгийг заавал дагаж мөрдөнө.” гэж тусгасантай холбогдуулан дагалдан боловсруулах хуулийн төслүүдийг сайтар тогтоох ;

2.Хуулийн дагуу хэрэгжилтийн хяналтын тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх зорилгын хүрээнд хуулийн төсөлд заасны дагуу байгуулах Зөвлөл, хорооны бүрэлдэхүүнд хувийн хэвшлийн ороцоог хангах, шардлагатай бол Худалдаа аж, үйлдвэрийн танхимын төлөөллийг оролцуулах замаар шийдвэрлэх ;

3.Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартын хувьд иргэд, хэрэглэгчдийн зүгээс гаргасан гомдлын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгох зорилгыг хангахад чиглэсэн зохицуулалтыг бий болгох.

Хуулийн төслийн шинэчлэн найруулсан байх бөгөөд дараах давхардал, хийдэл, зөрчил үүссэн байгааг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

1.Хуулийн төсөлд Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн “төв байгууллага” гэж нэр томъёог хэрэглэсэн нь хууль батлагдсаны дараа

хууль хэрэглээнд тодорхойгүй байдал үүсдгийг анхаарч Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн төрийн захиргааны байгууллага гэсэн агуулгаар өөрчлөн тусгах;

2.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн орон нутгийн хэрэгжүүлж байгаа чиг үүрэг, түүнчлэн мөн хуульд заасны дагуу нийслэлийн чиг үүрэгт стандарт хэрэгжүүлэх асуудал мөн харьяалагдаж байгааг анхаарч, аймаг, нийслэлийн стандартчлал тохирлын үнэлгээний газрын даргыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцхгүйгээр шууд томилохоор зарчмын өөрчлөлтийн талаар хуулийн төслийн үзэл баримтлалд тусгах;

3.Хуулийн төслийн тусгасан стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний дүрэм, журам, заавар, боловсруулах, батлах зохицуулалтыг эргэн харж, журмаар зохицуулах харилцааг аль болох хуулийн төсөлд тусгах замаар шийдвэрлэх, зайлшгүй шаардлагатай бол Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн тусгайлан батлах журмын нэр, зохицуулах асуудлыг тодорхой тусгах;

4.Хуулийн төслийн стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулах эрх олгох, цуцлах зохицуулалтыг аливаа зөвшөөрөл хэлбэрт оруулахаас зайлсхийж харин бүртгэлийн хэлбэрээр явуулж болохыг хуулиар зөвшөөрсөн тул Зөвшөөрлийн тухай хуулийн энэхүү зохицуулалтыг ашиглах;

5.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд хотын стандартын асуудлыг зохицуулсан. Тус стандарт буюу ойлгомжгүй байдлыг арилгахад чиглэсэн зохицуулалт тусгасан боловч үүнтэй холбогдуулан дагалдуулан боловсруулах хуулийн төслүүдийг анхаарах;

6.Хуулийн төсөл итгэмжлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байхаар тусгажээ. Итгэмжлэлийн байгууллага болон итгэмжлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хуулийн нэр томъёоны хувьд ялгаатай бөгөөд үүнийг хуулийн төсөлд дахин нягталж тодорхой болгох, эсхүл хуулийн төслийн үзэл баримтлалд тусгах;

7.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар хаалттай мэдээллийг хуульд заасан тусгаж болох ч хаалттай мэдээллийг ашиглахтай холбоотой зохицуулалтыг тодорхой тусгах.

Хуулийн төслийг боловсронгуй болгохд хууль зүйн техникийн хувьд анхаарах зарим асуудал болох

1.Хуулийн төслийн бүтцийн хувьд талаас илүү хувь буюу ихэнх зохицуулалт нь байгууллагын тогтолцоо бүрэн эрхийн талаарх зохицуулалт байгааг анхаарч хуулийн төслийн зорилгод нийцүүлэн стандартчлал тохирол техникийн зохицуулалтын үйл ажиллагааг илүү процесжуулах, зохицуулалтын шинжтэй заалтуудыг нэмэгдүүлж, иргэн хуулийн этгээдэд болон хэрэгжүүлэх этгээдэд тодорхой болгоход анхаарах;

2.Хуулийн төслийн бүлгийн дарааллын дахин нягталж, стандартчлал тохирол техникийн зохицуулалтын үйл ажиллагаатай холбоотой бүлгүүдийг эхэлж тусгах, дараа нь түүнийг хэрэгжүүлэх этгээдийн эрх үүрэг байгууллагын тогтолцоо, санхүүжилт, хариуцлага бусад зүйл гэсэн дарааллаар шинэчлэн тогтоох;

3.Шилжилтийн үеийн зохицуулалт шаардлагатай зарим зүйлийг анхаарах шаардлагатай. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл боловсруулах замаар зохицуулах боломжтойг анхаарах.

---oOo---